

2023

ХЭНТИЙ АЙМГИЙН ДЭЛГЭРХААН
СУМАНД БАЙРЛАХ
АВАРГА ТОСОН РАШААН СУВИЛАЛ
ХХК-ИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН



**ХЭНТИЙ АЙМГИЙН ДЭЛГЭРХААН СУМАНД БАЙРЛАХ
АВАРГА ТОСОН РАШААН СУВИЛАЛ ХХК-ИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

/Регистрийн дугаар: 2644495/

2023 он

1. ОРШИЛ

1.1.	Үйл ажиллагааны танилцуулга.....	2
1.2.	Хүчин чадал.....	2
1.3.	Брилга байгууламж.....	2-3
1.4.	Эмчилгээний төрөл.....	4-5
2.	Байгаль орчин нийгэм эдийн засгийн төлөв байдлын товч.....	6-7
3.	Төслийн гол болон болзошгүй товч тодорхойлолт.....	8-9
4.	Байгаль орчны менежментий төлөвлөгөөний биелэлт.....	10
4.1.	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт.....	11-14
4.2.	Орчны тохижилт ногоон байгууламжийн төлөвлөгөөний биелэлт.....	15-16
4.3.	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт.....	17
4.4.	Хог хаягдал сайжруулах менежментийн төлөвлөгөөний биелэлт.....	17-19
4.5.	Орчны хяналт шинжилгээний ажлын биелэлт.....	19-21
4.6.	Байгаль орчны аудит хийлэсэн байх.....	22
4.7.	Байгаль орчны хамгаалах менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэд зарцуулсан мөнгөн дүн.....	23

ОРШИЛ

Монгол Улсын “Байгаль орчныг хамгаалах тухай хууль”, “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хууль болон бусад холбогдох хууль, Байгаль Орчин Аялал Жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29 өдрийн А/618 тоот тушаал “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журмын дагуу боловсруулсан болно.

НЭГ. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Аварга тосон рашаан сувилал нь 1969 онд Аваргын бүлэг рашааныг түшиглэн байгуулагдсан магадлан итгэмжлэгдсэн улсын үйлчилгээтэй эрүүл мэндийн байгууллага юм. Сувилал нь улаанбаатар хотоос 270 км зайд Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын 3 дугаар багт эмчилгээний рашаан нуурын эрэг дээр шаврын ордын дэргэд байралдаг ба 9 га талбайг хамарсан эмчилгээ, сувилгааны объектууд, сувилуулагчдын амрах байруудтай. Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй нийт сувиллын зах зээлийн 19%-ийг эзэлдэг Монголын хамгийн том амралт сувиллын цогцолборын нэг.

2.1 Хүчин чадал

Сувилал нь 6 төрлийн эмчилгээ, 8 төрлийн өрөө байр, өдрийн 5 удаагийн хоол цай болон 4 төрлийн спорт амралтын үйлчилгээгээр нэг ээлжиндээ 400-450 хүн хүлээн авч 90-100 ажилтантайгаар дулааны улиралд /6-9 сард / үйл ажиллагаа явуулдаг.

1.1.1 Барилга байгууламж

Эмчилгээ, сувилгааны объект: Эмчилгээ, сувилгааны объект нь 1992 онд ашиглалтанд орж их засвар, өргөтгөл шинэчлэл хийгдсээр ирсэн. 5.3 тэрбум төгрөгийн “Аураг Эрүүл Мэндийн Цогцолбор” төслийн бүрэн хэрэгжих 2019 онд хуучин эмнэлгийн барилга байгууламжаа 520 мкв –аар өргөтгөн эмчилгээний тасгуудыг шинэчлэн зохион байгуулалтыг хийж, тоног төхөөрөмж, багаж хэрэгслээр хангасан. 2020 онд эмчийн үзлэгийн 6 тасаг, эмчилгээ сувилгааны 6 тасаг, 8 кабинетаар 21 нэр төрлийн эмчилгээ, сувилгааг хийж байна.

Сувилуулагчийн амралтын барилга байгууламж: Сувилуулагчийн ая тухтай амарч сувилуулах нөхцлийг бүрэн хангасан 1 ээлжийн 400-450 сувилуулагч хүчин чадалтай. 127 өрөө бүхий 6 барилга байгууламжтай.

Аураг буудал- 2013 онд ашиглалтанд орсон дотроо ариун цэврийн өрөөтэй гэр бүлийн люкс 23 өрөөтэй 3 давхар буудал.



Зураг 1. Аураг зочид буудал

Рашааны буудал- 2016 онд ашиглалтанд орсон дотроо ариун цэврийн өрөөтэй 16 өрөө бүхий 4 байр буудал.



Гэр бүлийн байр- 2019 онд ашиглалтанд орсон хоёр талдаа террастай 36 байр орчин үеийн ариун цэврийн бүхий 3 өрөөтэй.



Дүнзэн байр- 2011 онд ашиглалтанд орсон дотроо ариун цэврийн өрөө бүхий 6 өрөөтэй.

Гэр хотхон- Дотроо эко модон тавилга хэрэгсэлтэй, сийлбэртэй 2-3 ортой 10 гэр хотхон. 3-4 ортой энгийн 20 гэртэй.

Зочны байр- 1999 онд ашиглалтанд орсон энгийн 7 өрөөтэй 2 байр.

Энгийн буудал- Өвлийн зоогийн газартай залгаа 1996 онд ашиглалтанд орсон. Хүйтэн сэрүүний улиралд сувилуулагч хүлээн авах боломжтой, дотроо нийтийн ариун цэврийн өрөөтэй нийт 12 өрөө 27 ортой.

Үйчилгээний барилга байгууламж- Зоогийн газар 2013 онд ашиглалтанд орсон. 700 мкв ашигтай талбайтай, 140 суудалтай хоолны “А” заал, 160 суудалтай, хоолны “Б” заалтай нэг ээлжиндээ 300

сувилуулагч 2 ээлжээр 600 сувилуулагчид үйлчлэх хүчин чадалтай. Хоол зоогийн газар нь хоол үйлдвэрлэл, хоол түгээлт гэсэн 2 хэсэгтэй.

Манай сувилал нь эмнэлгийн үйлчилгээний алба, хоол үйлдвэрлэлийн алба, хоол үйлчилгээний алба, зочны үйлчилгээний алба, техник үйлчилгээний алба гэсэн 5 үндсэн алба нэгжтэй. Жилдээ 4500-5000 үйлчлүүлэгч хүлээн авч 7.5 дундаж ор хоногийн гүйцэтгэлтэй ажилладаг.

1.2 Эмчилгээний төрөл

Нарийн мэргэжлийн эмч нарын баг ажиллаж сувилуулагч бүрийг үзэж тусгайлсан эмчилгээний хөтөлбөрөөр эмчилнэ. Эмчилгээнүүд:

- Шавар эмчилгээгээр сэргээн засах
- Рашаан нуурын эмчилгээ
 - Тосон нуурын эмчилгээ
 - Аураг рашаан
 - Байгалийн давсан зам
 - Нуурын эргийн элсэн эмчилгээ
 - Наран шарлага
- Бариа засал
- Физик эмчилгээ
- Биеийн тамир эмчилгээ
- Уламжлалт эмчилгээ
- Фитнесийн кабинет

Аварга тосон рашаан сувиллын эмчилгээний тасгуудын хүчин чадал нь:

- ☞ Шавар эмчилгээний тасаг: Шавар тавих 20 өрөө 8 суудал 1 ээлжиндээ 16 хүнд өдөрт 200-хүнд үйлчлэх хүчин чадалтай.
- ☞ Физик эмчилгээний тасаг: 15 төрлийн аппаратаар шарлага болон бусад физик эмчилгээ хийдэг.
- ☞ Бариа заслын тасаг: бариа заслын 5 кабинетээс бүрдэнэ. Өдөрт 180-200 хүнд үйлчилдэг.
- ☞ Уламжлалт эмчилгээний кабинет: Уламжлалт анагаах ухааны эмч, хариуцаж ажиллана. /судас барьж оношилно/ Шаардлагатай үед зүү, төөнүүр, хануур эмчилгээг хийнэ.
- ☞ Биеийн тамир эмчилгээний кабинет-эмчилгээний дасгалууд болон бясалгалын дасгал хийлгэдэг.
- ☞ Фитнесийн кабинет-Чийрэгжүүлэх дасгалын 10-аад төрлийн тоног төхөөрөмжтэй биеийн тамирын дасгалжуулагч багш хариуцаж ажиллуулдаг.

Аварга тосон рашаан сувиллын эмчилгээний онцлог дараах байгалийн элементүүдийг ашигладаг.

Тосон шавар: Аварга тосонгийн анагаах шавар нь байгалд ховор тохиолдох өндөр эрдэсжилттэй, наалдамхай чанартай 3 төрлийн улаан шар, саарал, хар өнгөтэй нарийн ширхэгтэй тослог, лаг шавраас бүрдэнэ. Шаврын бүтцийн ширхэг хичнээн нарийн бөгөөд тослог, наалдамхай шинж чанартай байх тусам анагаах чанар нь сайн байдаг. Аварга тосонгийн эмчилгээний шавар нь дулааны физик чанар биологийн идэвхит бодисыг агуулсан органик эрдэсийн бүрэлдэхүүн, төмөр, зэс, кабалетын ислүүд, амин хүчлүүд, нүүрс ус төрөгч, хүхэрт ус төрөгч, азот, радон болон даавар, антибиотек, витамин төст нэгдлүүдийнхээ ачаар эмчилгээний өндөр ач холбогдолтой шаварт тооцогддог. Эмчилгээний шавар нь нянгийн эсрэг үйлчилгээтэй байдаг. Хүний биед шавар эмчилгээний үзүүлэх нөлөөнд дулааны үйлчилгээ голлох үүрэгтэй байдаг. Дулааны нөлөөгөөр шавар тавьсан биеийн хэсэгт судас тэлж, цусны эргэлт сайжирч, биеийн температур нэмэгдэж бодисын солилцоо сайжирдаг байна. Рашаан ус, шавар эмчилгээний эхний үед булчингийн агшилт суларч тамир доройтож байгаа мэт боловч курс эмчилгээний төгсгөлд цусны судлуудын тонус нэмэгдэж ургал мэдрэлийн цочрол багасч, булчингийн агшилт хүчтэй болон биеийн ерөнхий байдал сайжирдаг. Шавар эмчилгээ нь биеийн эсэргүүцлийг нэмэгдүүлж цусан дахь залгих болон хамгаалах эсийн чадварыг нэмэгдүүлдэг байна.

Тосон нуур: Нуурын эргийн элс нь нуурын доор байх эмчилгээний шаврын үргэлжлэл болох ба Аварга тосонгийн анагаах шавраас дутахгүй өндөр эрдэжилттэй, олон төрлийн микро элемент агуулсан том ширхэгтэй элсээр бүтнэ. Нуурын эргийн элс нь рашаан нуурын хаялгаар байнга эрдэсжиж байдаг. Аваргын бүлэг рашааны эмчилгээний нэг хэсэг нь нуурын эргийн эрдэсжсэн элс, нарны эгц тусгал бүхий нуур орчмын эмчилгээний био уур амьсгал, хужиран зам зэрэг нь анагаах ухааны олон төрлийн хүчин зүйлийг нэг дор цолцлоосон эмчилгээний ач холбогдол өндөртэй чухал хэсэг юм. Рашаан нуур нь олон мянган жилийн настай бөгөөд өндөр эрдэжилттэй, найрлагандаа олон төрлийн органик бодис агуулсан, шавар, элсэн дээр газрын гүний усны ундаргаар тогтсон байгалийн рашаан юм. Тосон нуурын рашаан ус нь карбонат-гидрокарбонат, хлорт натри төрлийн өндөр эрдэжилттэй жинхэнэ давст нуур юм. Рашаан нууранд орсноор хүний биеийн эрүүл мэндийг дэмжиж дархлааг сайжруулах үйлчилгээг үзүүлдэг байна. Нуурын усны долгионд хүний биед сайн макро болон микро элементүүд байдаг ба ялангуяа гормоны болон бодисын солилцоог сайжруулагч олон тооны биогений өдөөгч, дотоод шүүрлийн булчирхайн ажиллагааг идэвхжүүлэгч бодисууд байдаг ба тэдгээр нь нүдэнд харагдахгүй талст хэлбэрийн нимгэн давхаргаар арьсыг бүрхэж биед шингэн хүний бие организмыг дэмждэг байна.

Ауруг рашаан: Ауруг рашаан нь нүүрс хүчлийн хий /CO₂/-р баялаг, 88 метрийн гүнээс ундрэн гардаг, хүйтэн рашаан ус юм. Рашааны найрлагад орсон нүүрс хүчлийн хий, эрдэжилтээс гадна фтор 1.5-2 мг/л, 2 валенттай төмөр 5-10.4 мг/л хүртэл агуулгатай байдаг ба магни, титан, бари, зэс, лити, никел, цайр оролцсон байдаг. Нүүрс хүчлийн хийт рашаан ус нь биеийн ерөнхий тамир тэнхээг сэргээх үйлчилгээтэй бөгөөд бие махбодын эд эсийн хүчилтөрөгчийн хангамж ба оюуны чадварыг сайжруулахаас гадна ходоод гэдэсний архаг үрэвсэл, элэг, цөс, нойр булчирхай, сахарын дебет, эрдсийн солилцооны алдагдал зэрэг дотор эрхтний өвчин, ходоодны хүчил ихсэх, багасах, мөн амны хөндий, буйлны үрэвсэл, хамар хоолойн харшлын гаралтай өвчин, тархины даралт уналтад шавших маягаар хэрэглэгдэнэ.

Байгалийн давсан зам: Аваргын бүлэг рашааны эмчилгээний нэг хэсэг болох нуурын давлагааны хаялгаар тогтсон, рашааны шинж найрлагатай, анагаах давсан замаар хөл нүцгэн алхах нь хөлний улнаас массаж болох төдийгүй даралт бууруулах, ядаргаа тайлах, биеийн эсэргүүцлийг сайжруулах зэрэг давсан агуйн эмчилгээг үзүүлдэг байна.

Нуурын эргийн элс: Нуурын эргийн элс нь нуурын доор байх эмчилгээний шаврын үргэлжлэл болох ба Аварга тосонгийн анагаах шавраас дутахгүй өндөр эрдэжилттэй, олон төрлийн микро элемент агуулсан том ширхэгтэй элснээс бүрдэнэ. Нуурын эргийн элс нь рашаан нуурын хаялгаар байнга эрдэсжиж байдаг.

ХОЁР. БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

2.1 Газрын гадарга

Хэнтий аймгийн нутгийн хойд хэсэг ойт хээр, уул нурууд нь ерөнхийдөө д.т.д. дунджаар 2100-2600 м орчим өндөрт өргөгджээ. Онон Балжийн голоос урагш хээрийн бүс залгана. Эндхийн уул нурууд нь намссаар ухаа гүвээ цав толгодод аажмаар шилжинэ. Уулсын өндөр нь д.т.д дунджаар 1300- 1500 м ерөнхийдөө нэгэн жигд өндөртэй. Төсөл хэрэгжиж буй талбай нь далайн түвшинөөс дээш 1240-1260 метрийн өндөрт оршиж байна.

Газрын гадаргын эвдрэлийн өнөөгийн төлөв байдлыг үнэлсэн дээрх хүснэгтээс харахад төсөл хэрэгжих талбай нь 0-3⁰-ийн налуутай. Үйл ажиллагаанд өртөөгүй байгаа талбайд 50-70 хувийн ургамалжилттай, гадаргад элсэн бүрхэц, хад чулуу багатай талбай байна.

2.2. Уур амьсгал

Дэлгэрхаан сум нь Монгол орны физик газар зүйн мужлалын хувьд Хангай Хэнтийн уулархаг их муж Хэнтийн мужийн Хэнтийн захын уулсын тойрог, Монголын дорнод талын их муж Халхын дундад ухаа гүвээт талын тойргийн заагт оршино. Дэлгэрхаан сум нь уур амьсгалын хувьд эрс тэс уур амьсгалтай хуурайдуу сэрүүн зунтай бүсэд нөхцөлд оршино. Хамгийн хүйтэн үе нь 1-р сар бөгөөд дундаж температур нь өвөлдөө -15-аас -40 хэм хүртэл хүйтэрдэг бол хамгийн халуун өдөр нь 7 сард ба зуны дундаж температур +15-аас +37 хэм хүрдэг байна.

Голдуу хаврын улиралд салхины хүч 12м/сек-ээс 14м/сек хүрч зарим үед 16- 18м/сек хүрч салхилдаг. Өвлдөө дунджаар 5-аас 10 см зузаан усан бүрхүүл тогтдог. Жилийн анхны бороо 4 сарын эхээр анхны цас 9-р сарын дундуур ордог.

- 1 дүгээр сарын дундаж температур нь -17 о С
- 7 дугаар сарын дундаж температур +24 о С
- Агаарын үнэмлэхүй дулаан 35,5-40 о С дулаан, хамгийн хүйтэн нь 38-40 о С хүрдэг.
- Жилийн дундаж салхины хурд 1,6 м/с

2.3 Гадаргын ус

Дэлгэрхаан сумын нутгийн баруун болон өмнөд хилийн дагууд Хэрлэн гол урсах бөгөөд нутгийн баруун өмнөд хэсгээр аажим тохойрон зүүн тийш гольдрол нь эргэдэг. Үүнийг Хэрлэнгийн Их тохой гэж нэрлэдэг. Сумын төвийн дэргэдээс эх авсан Аваргын гол урагш урссаар Хэрлэн голын солгой талаас цутгадаг нэгдүгээр эрэмбийн жижиг гол юм. Элстэйн гарамнаас эхлэн нутгийг зүүн талын хилийн шугамын дагууд урсах Цэнхэрийн гол баруун өмнөд талын хэсэгхэн газарт Дэлгэрхааны нутагт орж ирээд буцаж гаран Хэрлэн голын солгой талаас цутгадаг хоёр дахь нэгдүгээр эрэмбийн гол юм.

Нутгийн төв хэсгээр хойноос урагш сумын төв хүртэл Зүүн сайрын гол урсана. Харин Дэлгэрхан уулнаас эх авсан Баруун сайрын гол сумын төвийн баруун талаар 6 км орчим зайтай урагш өнгөрч Аваргын голын баруун гар талаас цутгана.

Төслийн талбай нь Тосон нуурийн эргээс 150 метрийн зайд усан сан бүхий газрын онцгой хамгаалалтын бүсээс 12 метрийн зайд энгийн хамгаалалтын бүсэд байрлана. Бүрд нуурийн эргээс 300 метрийн зайд, онцгой хамгаалалтын бүсээс 170 метр, энгийн хамгаалалтын бүсээс 80 метрийн зайд байрлаж байна.

2.4 Хөрсөн бүрхэвч

Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын нутаг дэвсгэрт байрлах “Аварга Тосон Рашаан Сувилал” ХХК төсөл хэрэгжүүлэгчтэй рашаан сувиллын газар нь 1969 оноос үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн. Гадаргын хэв шинжийн хувьд тал хээрийн хэв шинж давамгайлсан том жижиг олон нууртай, мөн голын эх болох газар тул нуга, намагтай газар байна. Үүнээс шалтгаалан нам дор газраа нугын болон аллювийн хөрс тархсан байгаа бол талархаг газраар хар хүрэн хөрс зонхилон тархсан байна. Газрын гадаргын өндөршил нь далайн түвшнээс дээш 1240-1260 метр орчимд хэлбэлзэнэ. Төслийн талбайн хувьд нуурын урд талын дэнж дээр байрлана.

Хэнтий аймгийн Дэлгэрхаан нутаг дэвсгэрт байрлах “Аварга Тосон Рашаан Сувилал” ХХК-ийн рашаан, сувиллын талбай нь талархаг хэв шинжтэй, нуурын хөндийн дэнжийн систем илэрнэ. Төслийн нийт талбай 10 га бөгөөд нуурын хөндий, голын эхээр нугын, аллювийн, талархаг газраар хар хүрэн хөрсний хэв шинж зонхилон тархсан байна.

Харшороон хөрс: Харшороон хэв шинжийн хөрс Монгол орны умарт, дорнод хэсэгт уулсын хоорондох нарийвтар ам хөндий, уул хаяалсан нам ухаа гүвээ, голын өндөр дэнж газраар 900-1000 м-ээс 1500-1600 м хүртэл үнэмлэхүй өндрийн түвшинд багаахан талбайг хамарч алаг цоог байдалтай тархдаг. Алаг өвс-үетэнт, үетэн-алаг өвст бүлгэмдэл бүхий зүйлийн бүрдлээр баялаг, өтгөн шигүү ургасан нугат-хээрийн ба хээрийн ургамалшил зонхилж хөрсний гадаргын 60-90%-ийг бүрхэнэ. Хөрс үүсгэгч эх чулуулаг нь гол төлөв делюви, пролювийн гаралтай сайр чулуурхаг хөнгөн шавранцар хурдас байх бөгөөд хөрсний гүн рүү сайр чулууны агууламж ихсэж давхаргын эзэлхүүний 70-90% хүрэх ч бий. Тал хөндийн харшороон хөрсөнд орчин үеийн цэвдэг байхгүй, харин эртний цэвдэгт үзэгдлийн ул мөр морфологийн хувьд хадгалагдаж үлдсэн байдаг.

Хүрэншороон хөрс: Энэ хэвшинжийн хөрс Монгол орны тал хээр, уулсын хоорондох хөндий хотгорт өргөргийн ба хотгорын бүс, дэд бүсүүд үүсгэж дорнод хэсэгт 600-700 м-ээс өрнөд хэсэгт 2300-2400 м хүртэл үнэмлэхүй өндөрт хамгийн түгээмэл тархсан байна. Ургамал бүрхэвчид нь үетэнт, агь-үетэнт, алаг өвс-үетэнт хуурай хээрийн ба заримдаа цөлөрхөг хээрийн ургамалшил зонхилж, харгана байнга тааралдана. Хөрс үүсгэгч эх чулуулаг (ССа) нь пролюви, делюви, эртний аллювийн болон салхин гаралтай сайргархаг хөнгөн шавранцар, сайргархаг элсэнцэр болон элсэн, заримдаа алтан химэрлэг (лесс) маягийн хурдасаас тогтоно. Хүрэн шороон хөрсөнд хялбар уусах давс болон гөлтгөнө ерөөс байхгүй, түүнчлэн мараалаг шинжтэй байх нь цөөн, хааяа тааралдахдаа үлдмэл мараалаг байдаг нь сонин. Хээр тал нутгаар олон жил хөрсний судалгаа хийж энэ тэрийг ажиж явахад жинхэнэ хээрийн мараа, орчин үеийн үүсэлтэй мараалаг хөрс бараг тааралдаагүй гэхэд болно.

2.5 Ургамлан нөмрөг

Дэлгэрхаан сумын нутаг дэвсгэрт дахь ургамлын төрөл зүйл нь уулын ойт хээрийн бүслүүрийн ургамлын ангилалд хамаарах ба энд ботууль, тужууны өвс, дааган сүүл зэрэг үетэн, заримдаг өвс бүхий уулын хээрийн ургамал болон таг, тагийн доод хэсгийн өндөр уулын ургамлаас гадна хээрийн ургамлууд холилдон ургадаг байна. Төсөл хэрэгжүүлэгчийн эзэмшлийн нийт талбайн 30-50%-д ургамлан нөмрөгтэй байгаа нь судалгаагаар тогтоогдсон бөгөөд цаашид Газрын тухай хуулийн дагуу нийт талбайг бүрэн хэмжээгээр олон наст өвслөг ургамлан бүрхэвчтэй, үүний арваас дээш хувьд бут, модлог ургамал ургуулах шаардлагатай болсон байна.

Төслийн талбайн зонхилогч ургамалд хиаг, хялгана, ерхөг, согоовор, агь, ганга голлосон нарийн өвс ургамалтай. Мөн бамбай, шар болон цэнхэр дэгд, лидэр, таван салаа, нохойн хошуу, ганга, чихэр өвс, хамба шарилж, цөс өвс зэрэг эмийн ховор ургамал ургадаг.

2.6 Амьтны аймаг

Төслийн талбайн орчим зэрлэг амьтан, шувууд, хоёр нутагтан зэрэг амьтад тархан нутаглах бөгөөд төслөөс амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөлөл бага байна. Гэвч амрагчдад амьтан үргээх, хууль бус ан хийхгүй байх талаар тогтмол зөвлөмж өгч ажиллах хэрэгтэй. Төслийн талбайд судалгаа хийх явцад үлийн цагаан оготно ихээр тархсан байдалтай буюу 1 м² талбайд дунджаар 25-30 оготны нүх тоологдож байна. Судлаачдын гаргасан хэмжээгээр үлийн цагаан оготно нь нэг га-д 100-гаас доош үлийн цагаан оготно байж болно хэмээн үздэг бөгөөд талбайд байх оготны нүхний тооноос үзэхэд зохимжтой хэмжээнээс давсан байгаа тул цаашид үлийн цагаан оготной тэмцэх ажлыг эхлүүлэн арга хэмжээ авах шаардлагатай байна.

2.7 Тусгай хамгаалалттай газар нутаг, түүх соёлын өв

Төслийн талбай орчимд түүхийн үнэт, соёлын өв байхгүй. Аварга тосон нуур, Бүрд нуур зэрэг байгалийн дурсгалт томоохон нууруудаас 150-300 метрийн зайд оршино. Хамгийн ойролцоох улсын тусгай хамгаалалттай газар нь 15 км-т Хэрлэн тооно уулын байгалийн нөөц газар байна.

ГУРАВ: ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд, түүнд өртөх байгаль орчин, тухайлбал, газрын гадарга хэвлий, агаар, гадаргын болон газрын доорх ус, хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөг, амьтны аймаг, тусгай хамгаалалттай газар нутаг, түүх, соёлын дурсгал, төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн иргэд, нийгмийн байдалд үзүүлэх сөрөг нөлөөллийг чиглэл бүрээр тодорхойлж, нөлөөллийг бууруулах арга хэмжээ, эрсдэлийн үнэлгээ, төслийн экологи-эдийн засгийн үнэлгээ, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулан тусгасан байна.

Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн эрчим, орон зай, цаг хугацааны тархалтыг тодорхойлохын тулд Газарзүйн мэдээллийн системийн ArcGIS10.5 программ дээр нөлөөлөл буурах функц ашиглан нөлөөллийн эрчим, орон зай, цаг хугацааны тархалтыг тодорхойлсон болно.

Төслийн үйл ажиллагаатай шууд хамааралтай асуудлууд болон байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдтэй холбоотой асуудлыг матрицын босоо, хэвтээ шугамын дагуу ангилан байрлуулж харилцан үйлчлэлийг нь матрицын хүснэгт дээр тэмдэглэлээ. Аливаа үйл ажиллагааны чухам аль үе шатанд байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдэд илүү их сөрөг нөлөөлөл үзүүлэх нөхцөлтэй болохыг тодорхойлох нь энэ аргын гол зорилго болно. Энэ зорилгоор бид байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүд болон үйл ажиллагааны үе шатууд дахь нөлөөллийн эрчмийг үнэлсэн экспертүүдийн үнэлгээгээр матриц байгуулах аргыг ашигласан юм. Экспертийн үнэлгээг ихэнхдээ 1-10 балл гэж үзлээ. Нөлөөлөл хамгийн бага бол 1, хамгийн их бол 10-аар авсан болно.

Хүснэгт 1. Болзошгүй нөлөөлөл байгалийн хам бүрдэлтэй уялдах нь

№	Нөлөөлөл	Нөлөөллийн эх үүсвэр	Нөлөөллийн шинж чанар
Нэг: Агаар орчин			
1.1	Тоосжилт	Автомашин хөдөлгөөн, барилгын ажлын үе шатанд болон амрагчид, ажилчдын хөдөлгөөн болон бүх төрлийн үйлчилгээ хангамж, түлш хог хаягдал гэх мэт	Улирлын чанартай тархах, хамрах хүрээ хязгаарлагдмал
1.2	Дотоод шаталтын хөдөлгүүрийн хорт хий, угаа угаар	Автомашин	Агаар бохирдуулагч шугаман эх үүсвэр болох ба хадгалагдах тархах хүрээ хязгаарлагдмал
Хоёр: Усан орчин			
2.1	Хатуу болон шингэн хог хаягдал	<ul style="list-style-type: none"> - Ахуйн болон шатах тослох материалын хаягдал - Бохир ус дамжуулах хоолойн бүрэн бус байдал - Цэвэрлэх байгууламжийн эвдрэл, гэмтэл - Хүмүүсийн анхаарал хайхрамжгүйн улмаас үүсэх аливаа хог хаягдал, шатах тослох материал асгарах, гоожих 	<ul style="list-style-type: none"> - Шатах тослох материал асгарснаас хөрс, хөрсний ус бохирдож болзошгүй - Хур борооны усаар аливаа хог хаягдал, асгаралт угаагдаж хөрсний ус бохирдуулж болзошгүй.
Гурав: Хөрсөн бүрхэвч			
3.1	Хөрсний элэгдэл эвдрэл	Зориулалтын бус замаар явснаар явган жим, зам гарах, дагтарших, талхлагдах	<ul style="list-style-type: none"> - Хамрах хүрээ хязгаарлагдмал - Хөрсний физик, механик шинж чанар өөрчлөгдөж болзошгүй - Хөрсний элэгдэл эвдрэл үүсэх

			- Хөрсний шимт чанар буурах
3.2	Бохирдол	Ахуйн хог хаягдал ил задгай асгах, зориулалтын бус талбайд асгах	Хөрс бохирдсоноос хөрсний микробиологи, хүнд металлийн агууламж стандартын зөвшөөрөгдөх хэмжээнээс давах,
Дөрөв: Ургамлан нөмрөг			
4.1	Ургамлын талхагдал	<ul style="list-style-type: none"> - Зориулалтын бус замаар явснаар явган жим, зам гарах, ургамлан нөмрөг багасгах - Хүний хөл хөдөлгөөн, үйл ажиллагаанд өртөж буй зам, жим - Төслийн талбай, барилга, байгууламжуудын орчин 	Хэмжээ хязгаарлагдмал ба ургамалжуулалт хийснээр нөхөн сэргээх боломжтой
4.2	Ургамлан нөмрөг устах	Нэн ховор ургамлыг таньж мэдэхгүй устгах	Төрөл зүйл өөрчлөгдөж эсвэл устаж үгүй болно, гэвч төслийн талбайгаас аливаа ургамал түүх, ашиглах үйл ажиллагааг хориглоно.
4.3	Бохирдол	Ахуйн хог хаягдал болон шатах тослох материалын хаягдал	Ургамлын биомассын хэмжээ багасах, ургамлан нөмрөг устах нөлөөлөл үүсэж болзошгүй
Тав: Ан амьтан			
5.1	Хордолт	Ахуйн болон шатах тослох материалын хаягдал	Хөрсөн дахь бичил биетэн, шавж үрэгдэж болзошгүй
5.2	Идэш тэжээл	Ахуйн хог хаягдлыг ил задгай хаягдах	Зуун модны аманд зэрлэг ан амьтан /буга, согоо, үнэг, хярс/ орж ирдэг тул хог хаягдлаар хордох бөглөрөх магадлалтай байна.
Зургаа: Нийгэм эдийн засгийн орчин			
6.1	Үндсэн хөрөнгө	Татварын орлого, бүтээгдэхүүн, үйлчилгээний худалдан авалт	Улс орны төсөвт татвар төлөх, төслийн үйл ажиллагаа эхэлснээр төслийн талбайн ойролцоох аж ахуй эрхлэгчийн орлого нэмэгдэх,
6.2	Шинэ ажлын байр	Ажлын байр шинээр бий болно	Дүүргийн иргэдээс ажилд авах, тогтмол орлогын эх үүсвэртэй болгох, ахуй амьдралд нь тус дөхөм болох

ДӨРӨВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Манай сувилал нь 2023 онд “Богдын өндөрсүрвэй” ХХК-иар Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэмэлт тодотгол тайланг хийлгэн батлуулсан. Уг БОННУ-ийн хүрээнд батлагдсан Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дагуу 2023 онд байгаль орчныг хамгаалах, бохирдлоос урьдчилан сэргийлэхийн тулд хийсэн ажлуудыг энэхүү тайлангаар танилцуулж байна.

Байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөний зорилго нь: төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, нөлөөллийн үнэлгээгээр тогтоогдсон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд үүсэж болзошгүй сөрөг нөлөөллийн үр дагаврыг илрүүлэх, хянахад оршино.

Газрын тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.5 дах заалтад заасны дагуу Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны тайланг "Богдын өндөр сүрвэй" ХХК-иар хийж гүйцэтгүүлсэн

4.1 СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Энэ хэсэгт 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, түүнээс урьдчилан сэргийлэхэд хийсэн ажлуудын тайланг тусгав.

4.1.1 Сувиллын хүрээнд тээвэрлэлт хийх аж ахуй нэгж байгууллагыг сонгон шалгаруулахдаа техник хэрэгслийн засвар үйлчилгээнд бүрэн хамрагдаж улсын оношилгоонд орсон байх.

Тээвэрлэлт явуулах аж ахуй нэгж байгууллагыг сонгон шалгаруулахдаа улсын авто оношилгоонд бүрэн хамрагдсан, тээврийн хэрэгслийг татвар, даатгал төлсөн, засвар үйлчилгээ хийгдсэн байх шаардлагыг тавьсан. Уг шаардлагыг бүрэн биелүүлсэн “Эрдэм транс” ХХК-тай гэрээ байгуулан ажилласан.

Тээврийн хэрэгсэл
 Улсын дугаар: 0689УНП
 Загвар: KIA Granbird
 Үйлдвэрлэсэн он: 2007

Техникийн хяналтын үзлэгийн мэдээлэл
 ○ Үзлэгт орсон огноо: 2023/06/28
 ○ Үзлэгт дахин орох огноо: 2024/06/28
 □ Тэмцсэн эсэх: Тэмцсэн

Үндсэн цэс
 ○ Гэрчилгээний мэдээлэл
 ○ Оношилгооны мэдээлэл
 ○ Даатгалын мэдээлэл
 ○ Татвар, хурвиж
 ○ Торгуул
 ○ Ажилт, журамлагч
 ○ Хот хоорондын зам ашигласны хурвиж
 ○ Зогсоолын талбар
 ○ Төлбөрийн түүх

Тээврийн хэрэгсэл
 Улсын дугаар: 0689УНП
 Загвар: KIA Granbird
 Үйлдвэрлэсэн он: 2007

Гэрчилгээний мэдээлэл
 Арлын дугаар: КНО0ВК1U27К110737
 Үйлдвэрлэгч: KIA
 Загвар: Granbird
 Терөл: Хот хоорондын
 Үйлдвэрлэсэн улс: Өмнөд Солонгос (БНСУ)
 Үйлдвэрлэсэн он: 2007
 Өнгө: Цагаан
 Импортолгдсон огноо: 2007/08/21

Үндсэн цэс
 ○ Гэрчилгээний мэдээлэл
 ○ Оношилгооны мэдээлэл
 ○ Даатгалын мэдээлэл
 ○ Татвар, хурвиж
 ○ Торгуул
 ○ Ажилт, журамлагч
 ○ Хот хоорондын зам ашигласны хурвиж
 ○ Зогсоолын талбар
 ○ Төлбөрийн түүх

Гэрчилгээний мэдээлэл

Өндөр	Бүрэн	Үст	Хүн
2.49м	3.35м	12.49м	11.09тн

- Ангилал: D
- Хөдөлгүүрийн багтаамж: 12344
- Араа: -
- Шатаахуйн төрөл: Дизель
- Жолооны курс: Зүүн
- Суудлын тоо: 45

Тээврийн хэрэгсэл
 Улсын дугаар: 0606УНЦ
 Загвар: Hyundai UNIVERSE
 Үйлдвэрлэсэн он: 2013

Техникийн хяналтын үзлэгийн мэдээлэл
 ○ Үзлэгт орсон огноо: 2023/08/09
 ○ Үзлэгт дахин орох огноо: 2024/02/09
 □ Тэмцсэн эсэх: Тэмцсэн

Үндсэн цэс
 ○ Гэрчилгээний мэдээлэл
 ○ Оношилгооны мэдээлэл
 ○ Даатгалын мэдээлэл
 ○ Татвар, хурвиж
 ○ Торгуул
 ○ Ажилт, журамлагч
 ○ Хот хоорондын зам ашигласны хурвиж
 ○ Зогсоолын талбар
 ○ Төлбөрийн түүх

Тээврийн хэрэгсэл
 Улсын дугаар: 0606УНЦ
 Загвар: Hyundai UNIVERSE
 Үйлдвэрлэсэн он: 2013

Гэрчилгээний мэдээлэл
 Арлын дугаар: КММК18TRPC900431
 Үйлдвэрлэгч: Hyundai UNIVERSE
 Загвар: UNIVERSE
 Терөл: Хот хоорондын
 Үйлдвэрлэсэн улс: Өмнөд Солонгос (БНСУ)
 Үйлдвэрлэсэн он: 2013
 Өнгө: Саарал
 Импортолгдсон огноо: 2019/06/09

Үндсэн цэс
 ○ Гэрчилгээний мэдээлэл
 ○ Оношилгооны мэдээлэл
 ○ Даатгалын мэдээлэл
 ○ Татвар, хурвиж
 ○ Торгуул
 ○ Ажилт, журамлагч
 ○ Хот хоорондын зам ашигласны хурвиж
 ○ Зогсоолын талбар
 ○ Төлбөрийн түүх

Гэрчилгээний мэдээлэл

Өндөр	Бүрэн	Үст	Хүн
3.34м	2.49м	11.78м	11.35тн

- Ангилал: D
- Хөдөлгүүрийн багтаамж: 12344
- Араа: -
- Шатаахуйн төрөл: Дизель
- Жолооны курс: Зүүн
- Суудлын тоо: 45

4.1.2 Гадна талбайн гэрэлтүүлгийг хөдөлгөөн мэдрэгчтэй сэргээгдэх эрчим хүчээр ажилладаг байхаар төлөвлөх.

Эдэлбэр газарт төлөвлөгөөний дагуу сэргээгдэх эрчим хүчээр ажилладаг гэрэлтүүлэгүүдийг нэмж байршуулсан.



4.1.3 Нэр, хаяг, чиглэл заасан тэмдэг тэмдэглэгээ байршуулах.

Төлөвлөгөөний дагуу сувиллын авто зогсоол, хүлээн авах тооцооны төв, эмнэлгийн үүдэнд дуугүй хөтөчийн сабар байршуулсан ба барилга байгууламж бүрийн хаягийг харагдахуйцаар байршуулсан.



4.1.4 Унд ахуйн усны нэг худагт баталгаат тоолуур суурилуулах

Унд ахуйн худагт баталгаат тоолуурыг мэргэжлийн байгууллагаар суурилуулсан.



4.1.5 Усыг хэмнэлттэй ашиглах тухай анхааруулах хуудас, санамжийг байрлуулах

Сувиллын хэмжээнд ус ашигладаг эх үүсвэр бүрт ус хэмнэлттэй ашиглах санамж хуудсуудыг байршуулсан ба сургалтуудыг тогтмол хийж хэвшсэн.

4.1.6 Тосон болон бүрд нуурыг хамгаалах зөв зохистой ашиглах талаарх сургалт зохион байгуулах

7 хоног бүр сувиллын эмч нар сувилуулагчдад нуурыг зүй зохистой ашиглах, хамгаалах талаар мэдээлэл, сургалт хийдэг. Ажичлдад сар бүр сургалт орж хэвшсэн.



Аймаг, сум орон нутгаас зохион байгуулсан сургалт, зөвлөмжүүдэд хамрагдаж, мөрдөн ажилласан.



4.1.7 Галын аюулгүй байдлыг хангаж ажиллах

Сувиллын байгууламжуудад хэнтий аймгийн онцгой байдлын газраар “Галын аюулгүй байдлын дүгнэлт” хийгдсэн / Хавсралт/ ба байгууламжуудад стандартын дагуу галын хор самбарууд, галын сарай байршуулан галын аюулгүй байдлыг хангаж ажилласан



4.1.8 Авто машины зогсоолыг хатуу хучилттай болгох

Машины зогсоолын хэсгийг хашаа татаж, Харуулын байрыг шинээр барьж ашиглалтад оруулсан ба үндсэн 2 ажилтан ажилласан. Сувицуулагчдын машиныг зогсоолын хэсэгт байршуулан нийтийн эзэмшлийн талбайд машин оруулахгүй байх үүрэгтэй ажилласан.



4.1.9 500 хүний хүчин чадалтай цэвэрлэх байгууламж байгуулах

2023 онд цэвэрлэх байгууламжийг туршилтаар ашиглаж үзсэн ба хэд хэдэн хэсэгт засч сайжруулах хэрэгтэй байгаа болно.

“Экобиотех” ХХК-аар Биологийн бүрэн цэвэрлэх байгууламжийн технологийн зураг, техникийн төслийг боловсруулан батлуулсан. Техникийн төслийн дагуу биологийн идэвхит бактерийн уламжлалт болон дараалал биореакторын /SBR/ хосолмол систем бүхий бага оврын цэвэрлэх байгууламж бариж ашиглалтад оруулсан. Уг цэвэрлэх байгууламж нь 500 хүний буюу хоногт 75 м³ ахуйн бохир ус цэвэрлэх хүчин чадалтай. Цэвэрлэх байгууламжийн үндсэн үзүүлэлт:

- Цэвэрлэх байгууламжийн нийт эзэлхүүн 185 м³
- Агаарын тоо хэмжээ цагт 28 м³
- Байнгын шаардлагатай ашиглалтын биомассын хэмжээ 319.7 кг
- Цэвэрлэх байгууламжийн тооцооны хоногийн ачаалал:
 - ХХХ 36 кг/өдөр
 - БХХ5 18 кг/өдөр
 - Хуурай бодис 21 кг/өдөр
 - Азот 3.3 кг/өдөр
 - Фосфор 0.54 кг/өдөр
- Цаг тутамд ногдох агааржуулалтын дээд хугацаа 45 минут
- Бүрэн ачаалын үед өгөх агааржуулах нийт хугацаа хоногт 12.6 цаг
- Агаарын тоо хэмжээ 28м³/цаг

Зураг 2. Биологийн цэвэрлэх байгууламжийн технологийн схем

Байгууллагын цэвэрлэх байгууламжийг “Хүрээлэн буй орчин. Усны чанар хаягдал ус ерөнхий шаардлага” 4943:2015 стандартыг нийцүүлэн хоногт 75м³ бохир усыг хүлээн авах хүчин чадалтайгаар шинэчлэн барилгын ажлыг хийж байна. Одоогийн байдлаар сэндивчен барилга, 6.8x12x4 м-ийн харьцаатай 2 хэсэг 6 тасалгаа бүхий танк, суурь цутгалттай.



4.2 ОРЧНЫ ТОХИЖИЛТ НОГООН БАЙГУУЛАМЖИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

4.2.1 Төслийн талбайн орчимд нөлөөлд өртсөн талбайг нөхөн сэргээх

Манай сувилал нь газрын хэвлий хөндөхгүй, мод бут тайрах, шилжүүлэх үйл ажиллагаа явуулахгүй. Харин өөрийн эзэмшлийн талбай дахь ногоон байгууламжийг нэмэгдүүлэх замаар орчныг тохижуулах, хөрсний элэгдлээс урьдчилан сэргийлэхийг зорьсон. Нийт 250 ш улиас модны суулгац, 50 ш нарс тарьж ургуулсан. Хуучин ногоон байгууламжаа байнгын тордож ажилласан бөгөөд цаашид ногоон байгууламжийн хувийг нэмэгдүүлэх зорилт тавин ажиллаасан.

4.2.2 Сувиллын эдэлбэр газрыг зүлэгжүүлэх

Эдэлбэр газарт 15000м² талбайд олон наст зүлэгний үр тариалсан.



4.2.3 Тэр бум мод төслийн хүрээнд орон нутагт ногоон байгууламж бий болгоход оролцоотой ажиллах

Менежментийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу 100ш халиас мод, 50ш агч, 50ш шар хуайсны суулгацыг Дэлгэрхаан сумын цэцэрлэгт хүрээлэнд тарьсан.



4.3 ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Үйл ажиллагааны явцад ахреологи, палеонтологийн олдвор, түүх соёлын дурсгалт зүйлс илэрээгүй болно.

4.4 ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙГ САЙЖРУУЛАХ

Манай сувилал нь хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг сайжруулах ажлын хүрээнд орчны бохирдлоос сэргийлэх зорилгоор хог хаягдлыг ил хаяхгүй байх, тусгай тэмдэглэгээ бүхий хогийн саванд цуглуулах, хуваарьт цэвэрлэгээ хийх, хог тээвэрлэх зэрэг ажиллагааг сувиллын хэмжээнд мөрдөх тусгай журмаар зохицуулдаг. Сувиллын хүрээнд гадна талын цэвэрлэгээ үйлчилгээг хариуцсан үндсэн орон тооны 1 ажилтантай ажилласан. Гадна талбайн ажилчин нь сувиллын эдэлбэр талбайг өдөр бүр цэвэрлэдэг.

Хог хаягдлын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2.3 дах заалтын дагуу Энгийн хог хаягдлын гэрээг Дэлгэрхаан сумын ОНӨҮГ-тай гэрээ хийн гэрээний дагуу хогны ачилт хийгдсэн болно. /гэрээг хавсаргав/. Сард 2 удаагийн давтамжтайгаар ахуйн хогны байгууламжийг автосмакс ашиглан жавиланаар ариутгаж хэвшсэн

4.4.1 Хог хаягдал хадгалах түр цэгт хог хаягдлыг 3-аас доошгүй төрлөөр ялгаж тэмдэгжүүлсэн байхаар төлөвлөж тохижуулах

6*2 хэмжээтэй түр хог хадгалах 3 таслагаа бүхий хогийн цэгийн шинээр барьсан. Суурийг бсм-ийн өндөртэй цутгалт хийж хөрсөнд нэвчихээс сэргийлсэн.



4.4.2 Тосон нуурын эдэлбэр газарт их цэвэрлэгээ хийх

Тосон нуурыг бохирдлоос хамгаалахын тулд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

- Сар бүрийн 15-ныг их цэвэрлэгээний өдөр болгон зарлаж бүх ажилчид Тосон нуурын хог хаягдлыг цэвэрлэн зориулалтын цэгт хүргэж ажилласан.

- Тосон нуурыг хамгаалах эргүүл гаргаж нуурын усанд шавартай биеэр орж бохирдуулахаас урьдчилан сэргийлж ухуулах сурталчилгаа хийсэн.
- Хуваариан шавар зарах асуудлаас урьдчилан сэргийлэхийн тулд эргүүл гарган ажиллуулсан.
- Нийт амрагч сувилуулагчдаа нуурын усанд орох, орчныг хамгаалах талаар заавар зөвлөмжийг тогтмол өгч ажиллалаа.



Нуурын эвдэрсэн сүүдвэрчүүдийг засаж яанзалсан



2023 онд энгийн хог хаягдлын 15 ш төмөр хогийн сав 3 ш түрдэг хуванцар хогийн сав шинээр авч байршуулсан.



Энгийн хог хаягдлын гэрээг Дэлгэрхаан сумын ОНӨҮГ-тай гэрээ хийн гэрээний дагуу хогны ачилт хийгдсэн болно. Сард 2 удаагийн давтамжтайгаар ахуйн хогны байгууламжийг автосмакс ашиглан жавиланаар ариутгаж хэвшсэн

Аюултай хог хаягдлын гэрээг Дэлгэрхаан сумын Эрүүл мэндийн төвтэй 2023 оны 05 дугаар сарын 25 өдөр гэрээ хийгдсэн болно. / Гэрээг хавсаргав/

4.5 ОРЧНЫ ХЯНАЛТ ШИЖИЛГЭЭНИЙ АЖЛЫН ХҮРЭЭНД

4.5.1 Рашаан ашиглах гэрээ байгуулан ажиллах

Рашаан ус ашиглах зөвшөөрөл бүхий гэрээг Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын Засаг даргатай 2023 оны 06 дугаар сард байгуулан ажилласан. Гэрээний дагуу рашаан ашигласны төлбөр болон 10,440,000 төгрөгийг төлсөн болно. / Гэрээг хавсаргав/

4.5.2 2023 оны ус ашиглах дүгнэлтийг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг УСНЫ ГАЗАР-аар гаргуулан, Хэрлэн голын сав газартай гэрээ байгуулан, № 22 тоот гэрээний дагуу ажилласан. Ашигласан усны төлбөрийг нэхэмжлэлийн дагуу төлсөн.

4.5.3 Эмчилгээнд ашиглагдаж буй шавраас дээж авах

MNS 5848:2008 эмчилгээний шаврын ангилал, техникийн шаардлагын дагуу эмчилгээнд ашиглаж буй шавраас ICP-28, Хөрсний микробиологийн 5 үзүүлэлтийн шинжилгээ хийлгэсэн. /дүгнэлт хавсаргав /

Шаврын шинжилгээ



ХАНЛАБ ХХК
Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 17-р хороо, Богд Жавзандамба
гудамж 34/6 тоот, Хан Рашаан компанийн байр
Утас: 70109968, 99995316
<http://www.khanlab.mn>



ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН

ЗАХИАЛГА №: 2023/1862

ЗАХИАЛАГЧИЙН НЭР: АВАРГА ТОСОН РАШААН СУВИЛАЛ

ДЭЭЖИЙН ТӨРӨЛ, ТОО: Шавар, 1

№	ЛАБОРАТОРИЙН ДУГААР	ДЭЭЖИЙН ДУГААР	ДЭЭЖИЙН ТОДОРХОЙЛОЛТ	ЭЛЕМЕНТ, %					ЭЛЕМЕНТ, мг/кг				
				Na	Ca	Mg	K	Fe _{минг}	As	Ba*	Be	Bi	Cd
1	Л-21267	1	Шавар	1.24	0.13	0.42	2.36	2.47	9.06	427.5	2.56	<10.0	<1.0
MNS5850:2019				-	-	-	-	-	20.00	-	-	-	3.00

№	ЛАБОРАТОРИЙН ДУГААР	ДЭЭЖИЙН ДУГААР	ДЭЭЖИЙН ТОДОРХОЙЛОЛТ	ЭЛЕМЕНТ, мг/кг									
				Co	Cr	Cu	La	Li	Mn	Mo	Ni	P	Pb
1	Л-21267	1	Шавар	10.69	57.43	54.49	42.88	47.41	232.5	<5.0	16.17	207.6	68.09
MNS5850:2019				50.00	150.0	100.0	-	-	-	5.0	150.0	-	100.0

№	ЛАБОРАТОРИЙН ДУГААР	ДЭЭЖИЙН ДУГААР	ДЭЭЖИЙН ТОДОРХОЙЛОЛТ	ЭЛЕМЕНТ, мг/кг									
				Sb	Se	Sr*	Ti	V	Y	Zn	Zr*		
1	Л-21267	1	Шавар	<10.0	<5.0	53.31	2869	125.7	24.77	121.6	106.5		
MNS5850:2019				-	10.00	800.0	-	150.0	-	300.0	-		

Чанарын менежер: Д. Пүрэвжаргал

Тайлбар: * - бүрэн захирахгүй. (Хаягс тоон утга)

Шинжилгээнд ирүүлсэн дээжийг 1 сар хүртэл хугацаагаар хадгална.

Сорилтын үр дүн зөвхөн тухайн дээжинд хамаарна. Дээжлэлтийн талаарх асуудлыг манай лаборатори хариуцахгүй болно.

ХҮЛЭЭН АВСАН ОГНОО: 2023.10.20

ДЭЭЖ БОЛОВСРУУЛАЛТ: хийгдсэн.

ШИНЖИЛСЭН ОГНОО: 2023.10.27

ХУУДАСНЫ ТОО: 1

Хамтран ажилласан таньд талархлаа.

Хуудас 1-1



ХАНЛАБ ХХК
Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 17 р хороо, Богд Жавзандамба
гудамж 34/6 тоот, Хан Рашаан компанийн байр
Утас: 70109968, 99995316
<http://www.khanlab.mn>



ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН

ЗАХИАЛГА №: МБ 2023/427

ЗАХИАЛАГЧИЙН НЭР: АВАРГА ТОСОН РАШААН СУВИЛАЛ

ДЭЭЖИЙН ТӨРӨЛ, ТОО: Шавар, 1

№	Лаб №	Дээжийн тодорхойлт	Дээжийн хэмжээ /г/	ҮЗҮҮЛЭЛТ				
				Бактерийн сөрөнхий тоо	Коллиформ гэдэсний бүлгийн нягтийн таныд	Халуунд гэсвэртэй гэдэсний бүлгийн нягтийн таныд	Клостридиум перфрингенсийн таныд	Гэдэсний бүлгийн эмгэг төрөгч ний
1	Л-1738	Шавар	200	4*10 ⁴	илрээгүй	илрээгүй	илрээгүй	илрээгүй
ШИНЖИЛГЭЭНИЙ АРГЫН СТАНДАРТ				MNS 6341:2012	MNS 5367:2004	MNS 5367:2005	MNS 6341:2012	MNS 6341:2012
ЗӨВШӨӨРӨГДӨХ ДЭЭД ХЭМЖЭЭ /MNS 3297:1991/				илрэхгүй 1г-д	илрэхгүй 1г-д	илрэхгүй 1г-д	илрэхгүй 1г-д	илрэхгүй 25г-д
Чанарын менежер: Д. Пүрэвжаргал								

Сорилтын үр дүн зөвхөн тухайн дээжинд хамаарна. Дээжлэлтийн талаарх асуудлыг манай лаборатори хариуцахгүй болно.

ХҮЛЭЭН АВСАН ОГНОО: 2023.10.23

ДЭЭЖ БОЛОВСРУУЛАЛТ: хийгдсэн.

ШИНЖИЛГЭЭ ЭХЭЛСЭН ОГНОО: 2023.10.23

ХУУДАСНЫ ТОО: 1

ШИНЖИЛГЭЭ ДУУССАН ОГНОО: 2023.10.31

Хамтран ажилласан таньд талархлаа.

Хуудас 1-1

4.5.4 Ундны усны ерөнхий химийн шинжилгээ хийсэн байх

Хэнтий аймгийн УЦУОШТ-тэй хийсэн 2023 оны 05 дугаар сарын 15 өдрийн гэрээний дагуу Агуурын чанар, Хөрсний чанар, Усны чанар, цацрагийн шинжилгээ хийлгэсэн.



УС ЦАГ УУР ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ
БАЙГАЛЬ ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ
ЛАБОРАТОРИ

Хэнтий аймаг Хэрлэн сум 2-р баг тэмүүжингийн
гудамж Н-13
Утас/Факс: 93028611, 98092200
E-mail хаяг: mnhe_oper@yahoo.com



УС ЦАГ УУР ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ
БАЙГАЛЬ ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ
ЛАБОРАТОРИ

Хэнтий аймаг Хэрлэн сум 2-р баг тэмүүжингийн
гудамж Н-13
Утас/Факс: 93028611, 98092200
E-mail хаяг: mnhe_oper@yahoo.com



Сорьцын дугаар: 04
Сорьц авсан газрын нэр, хаяг, утас: Аварга тосон Ундны ус
Сорьц авсан хүний нэр, албан тушаал: Агаарын техникч Б.Эрдэнэцэцэг
Сорьцын тоо, хэмжээ: 2,5 литр
Сорьцын төрөл: Ус
Сорьц авсан огноо: 2023-05-14
Лабораторид хүлээж авсан : 2023-05-18
Шинжилгээ эхэлсэн огноо: 2023-05-30
Хэвлэсэн огноо: 2023-06-20
Хуудасны тоо: 1/1

ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИЙН СОРИЛТЫН ДҮН

Тодорхойлсон үзүүлэлт Шинжилгээний арга стандарт	Сорьц авсан цэг Аварга тосон Ундны ус/	MNS 0900:2018 Хүлцэх агууламж мг/л
Жингэлдэх бодис /MNS 6836:2020/	Ж/Б мг/л	31.8
Перманганатын исэлдэх чанар /MNS 6833:2020/	Пич мг/л	1.12
Кальцийн ион /MNS ISO 1097:1970/	Ca ²⁺ мг/л	16.4
Магний ион /MNS ISO 1097:1970/	Mg ²⁺ мг/л	6.95
Аммоний ион /CA3 1-2020/	NH ₄ ⁺ мг/л	0.48
Нийт төмөр /MNS 4430:2005/	Fe мг/л	0.57
Хлорин ион /MNS 4424:2005/	Cl мг/л	5.2
Сульфатын ион /MNS 6271:2011/	SO ₄ ²⁻ мг/л	0.08
Нитритийн ион /MNS 6779:2019/	NO ₂ ⁻ мг/л	0.009
Нитратын ион /MNS 6834:2020/	NO ₃ ⁻ мг/л	0.04
Фосфатын ион /MNS ISO 6878:2001/	PO ₄ ³⁻ мг/л	0.082
Фтор /MNS 6272:2011/	F мг/л	1.27
Хатуулаг / MNS ISO 1097:1970/	Хатуулаг мг- эв/л	1.39
Натри Кали	Na+K мг/л	50.72
Цахилгаан дамжуулах чанар /MNS ISO 7898:1999/	EC µS/cm ³	291
Гидрокарбонат MNS 6832:2020	HCO ₃ ⁻ мг/л	194.0
Эрдэсжилт MNS ISO 1097:1970	мг/л	277.4
Орчин MNS ISO 10523:2001	pH	7.8

ХЯНАЖ БАТАЛГААЖУУЛСАН:
УЦУОШТӨВИЙН ДАРГА: /Б.ХЭРЛЭНЧИМЭГ /
ШИНЖИЛГЭЭ ГҮЙЦЭГТЭСЭН:
БОШ ЛАБОРАТОРИЙН ЭРХЛЭГЧ: /Б.ГАНГАНБАЙГАЛ /

Сорьцын дугаар: 05
Сорьц авсан газрын нэр, хаяг, утас: Аварга тосон төв Унд
Сорьц авсан хүний нэр, албан тушаал: Агаарын техникч Б.Эрдэнэцэцэг
Сорьцын тоо, хэмжээ:
Сорьцын төрөл: Агаар
Сорьц авсан огноо: 2023-05-14
Лабораторид хүлээж авсан : 2023-05-17
Шинжилгээ эхэлсэн огноо: 2023-05-22
Хэвлэсэн огноо: 2023-06-20
Хуудасны тоо: 1/1

ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИЙН СОРИЛТЫН ДҮН

Шинжилсэн үзүүлэлтийн нэр, хэмжих нэгж	Хүлцэх агууламж	Үр дүн
MNS 17.2.5. 12:88	Хүхэрлэг хий – SO ₂ , мг/м ³	0.450
MNS 17.2.5. 12:88	Азотын давхар исэл – NO ₂ , мг/м ³	0.200
CA3 A03	Тоос – нийт, мг- м ³	0.150

ХЯНАЖ БАТАЛГААЖУУЛСАН:
УЦУОШТӨВИЙН ДАРГА: /Б.ХЭРЛЭНЧИМЭГ /
ШИНЖИЛГЭЭ ГҮЙЦЭГТЭСЭН:
БОШ ЛАБОРАТОРИЙН ЭРХЛЭГЧ: /Б.ГАНГАНБАЙГАЛ /



УС ЦАГ УУР ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ
БАЙГАЛЬ ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ

Хэнтий аймаг Хэрлэн сум 2-р баг тэмүүжингийн
гудамж Н-13
Утас/Факс: 93028611, 98092200
E-mail хаяг: mnhe_oper@yahoo.com



УС ЦАГ УУР ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ
БАЙГАЛЬ ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ
ЛАБОРАТОРИ

Хэнтий аймаг Хэрлэн сум 2-р баг тэмүүжингийн
гудамж Н-13
Утас/Факс: 93028611, 98092200
E-mail хаяг: mnhe_oper@yahoo.com



Сорьцын дугаар: 13
Сорьц авсан газрын нэр, хаяг, утас: Аварга тосон төв Унд
Сорьц авсан хүний нэр, албан тушаал: Агаарын техникч Б.Эрдэнэцэцэг
Сорьцын тоо, хэмжээ: 800 гр
Сорьцын төрөл: Хөрс
Сорьц авсан огноо: 2023-05-24
Лабораторид хүлээж авсан : 2023-05-30
Шинжилгээ эхэлсэн огноо: 2023-06-02
Хэвлэсэн огноо: 2023-06-20
Хуудасны тоо: 1/1

ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИЙН СОРИЛТЫН ДҮН

Шинжилсэн үзүүлэлтийн нэр, хэмжих нэгж	Хүлцэх агууламж	Үр дүн
MNS3310:1991	Орчин- pH	-
MNS3310:1991	Чийг - %	0.97%
MNS3310:1991	Ялзмаг	3.9
MNS3310:1991	Аммиак- NH ₄ мг / л	43.4
MNS3310:1991	Нитрат – NO ₃ мг / л	24.8
MNS3310:1991	Сульфат- SO ₄ мг / л	554.9
MNS3310:1991	Фосфор (P2 O5) мг / л	14.9

ХЯНАЖ БАТАЛГААЖУУЛСАН:
УЦУОШТӨВИЙН ДАРГА: /Б.ХЭРЛЭНЧИМЭГ /
ШИНЖИЛГЭЭ ГҮЙЦЭГТЭСЭН:
БОШ ЛАБОРАТОРИЙН ЭРХЛЭГЧ: /Б.ГАНГАНБАЙГАЛ /

Сорьцын дугаар: 07
Сорьц авсан газрын нэр, хаяг, утас: "Аварга тосон төв"
Сорьц авсан хүний нэр, албан тушаал: Агаарын техникч Б.Эрдэнэцэцэг
Сорьцын тоо, хэмжээ:
Сорьцын төрөл: Цацраг
Сорьц авсан огноо: 2023-05-22
Лабораторид хүлээж авсан : 2023-05-30
Шинжилгээ эхэлсэн огноо: 2023-06-02
Хэвлэсэн огноо: 2023-06-20
Хуудасны тоо: 1/1

ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИЙН СОРИЛТЫН ДҮН

Шинжилсэн үзүүлэлтийн нэр, хэмжих нэгж	Хүлцэх агууламж	Үр дүн
CA3 A04	Цацраг – агаар мкЗв/ цаг	0.05

ХЯНАЖ БАТАЛГААЖУУЛСАН:
УЦУОШТӨВИЙН ДАРГА: /Б.ХЭРЛЭНЧИМЭГ /
ШИНЖИЛГЭЭ ГҮЙЦЭГТЭСЭН:
БОШ ЛАБОРАТОРИЙН ЭРХЛЭГЧ: /Б.ГАНГАНБАЙГАЛ /

4.5.5 Аварга тосон нуурын уснаас дээлэлт хийсэн байх

Бүрд нуур болон Аварга тосон нуурын усны найрлага чанарыг тодорхойлохын тулд дээж авч шинжилүүлсэн. Шинжилгээний дүнгээр:

Хүснэгт 2. Ерөнхий химийн шинжилгээ

№	Шинжилсэн үзүүлэлт	Олон улсын нэршил	Хэмжих нэгж	Бүрд нуур	Аварга тосон нуур
1	pH – Усан орчин	Hydrogen ions	-	9,29	9,83
2	Цахилгаан дамжуулах чанар	Electrical conductivity	мСм/см	59,8	2316
3	Исэлдэн ангижирах чанар		мS/m	-181	86
4	Хатуулаг	Total hardness	мг-экв/л	2,6	1,6
5	Натри	Na+K	мг/л	707,9	7275,5
6	Кальци	Calcium, Ca ²⁺	мг/л	52,1	24,05
7	Магни	Magnium, Mg ²⁺	мг/л	19,5	4.86
8	Карбонат	Carbonate, CO ₃ ⁻	мг/л	240	5640
9	Гидрокарбонат	Becarbonate, HCO ₃ ⁻	мг/л	1098	4453
10	Хлорид	Chloride, Cl ⁻	мг/л	312	1980
11	Сульфат	Sulfate, SO ₄ ²⁻	мг/л	25,5	59,3
12	Нитрат	Nitrate, NO ₃ ⁻	мг/л	0,12	0,86

4.5.6 Хаягдал ус хаях, зайлуулах гэрээний дагуу төлбөрийг төлсөн байх



БАТЛАВ. ЗАСАГ ДАГАА. /Э ТӨГӨЛДӨР/

ХАЯГДАЛ УСЫГ БАЙГАЛЬД ШУД НИЙЛҮҮЛЖ БАЙГАА ХУУЛИЙН ЭТГЭЭДТЭЙ БАЙГУУЛАХ УС БОХИРДУУЛСНЫ ТӨЛБӨРИЙН ГЭРЭЭ

2023 оны 08 сарын 01 Дугаар 01 Дэлгэрхаан сум

Нэг: Ерөнхий зүйл

Усны тухай хуулийн 24 дүгээр зүйл, 24.2 дэх хэсэгт заасны дагуу гаргасан

20...оны...р сарын...ны өдрийн... дугаартай хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрлийг үндэслэн нэг талаас ус ашиглуулагчийг төлөөлж дүүргийн... Засаг Засаг... Сум Сум... дэргын... дэргын... овогтой... овогтой... нөгөө талаас ус бохирдуулагчийг төлөөлж... айлаг, нийслэл... сум дүүрэг... баг, хороо... баг, тоотод... бүртгэлийн... бүртгэлийн... хун, хуулийн этгээдийг төлөөлж... албантүвшээтэн... нар ус бохирдуульсн төлбөр, нөхөн төлбөрийг төлөх талаар иарилцан тохиролцон энэхүү гэрээг 1 нэг жилийн хугацаатай байгуулав.

Хоёр: Гэрээний гол нөхцөл

2.1. Ус бохирдуулагч нь хаягдал усыг Хүрээлэн байгаа орчин, Усны чанар, Хаягдал ус, Ерөнхий шаварлага" МНС 4943:2015 стандартын норматив шаварлагад нийцүүлэн байгальд шууд нийлүүлнэ.

2.2. Ус бохирдуулагч нь Усны тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэгт заасны дагуу хаягдал усны чанарыг энэхүү гэрээний 2.1-д заасан стандартын норматив шаварлагад нийцүүлсэн тохиолдолд ус бохирдуульсн төлбөр, стандартын норматив шаварлагад нийцүүлээгүй тохиолдолд ус бохирдуульсн нөхөн төлбөрийг хаягдал усанд агуулагдах бохирдуулах бодисын хэмжээгээс хамаарь н 2-5 дахин шатлан өсгөх хэлбэрээр тооцож төлнө.

2.3. Төлбөр төлөгч нь Ус бохирдуульсн төлбөрийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэгт заасны дагуу хаягдал усан дахь бохирдуулах бодист ногдох төлбөр, нөхөн төлбөрийг дараа улирлын эхний сарын 20-ны өдрийн дотор харьяалах татварын албанд төлнө.

2.4. Ус бохирдуулагч нь дараах мэдээллийг улирал тутамд Сав газрын захиргаа, харьяа татварын албанд хүргүүлнэ. Үүнд:

2.3.1. Хаягдал ус нийлүүлдэг хүн, хуулийн этгээдийн нэр;

Төлбөрийн даалганаар 34001591

2023 оны 10 сарын 17 өдөр

Мэргэжлийн үйлчилгээний байр ОУС-ийн 182 тоот тусламжлагч ОУС-ийн

Төлөгч	Данс	Дүн
Хүн	Аварга тосон нуурын сувилал ХХК	Либст
Төлөгчийн Хүснэгт	Хөвч данс	8038069394
Бол	ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗАР	Кредит
Хүснэгт	Хөвч данс	5176120446
Мөнгөнхий дүн (тогтооно)		180,809.28
Мөнгөнхий дүн (хөгсгөр)		
Нэг сарын мөнгөний найман сарын өсөн төлбөр хөрөнгийн найман мөнгө		
Бариаг хүлээн авсан буюу өмнө үйлчилгээг гүйцэтгүүлсэн өснө		
2023 оны 10 сарын 17 өдөр		
Төлбөрийн зориулалт (баримт болон өмнө үйлчилгээний нэр, дагалдах баримтын дүнд)		
33106327121 № бохирдуульсн төлбөр 2023 он		
Төлөгч	ЗАХИРАЛ	Д.Т.МЭНДЭМБЭР
Төлөгчийн	ЕРӨНХИЙ	ТӨЛБӨР

4.5.7 Унд ахуйн усны гэрээ хийсэн байх

2023 оны усны дүгнэлтийг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг УСНЫ ГАЗАР-аар гаргуулан Хэрлэн голын сав газрын захиргаатай гэрээг хийж гүйцэтгэн, ашигласан усны төлбөрөө бүрэн төлсөн.

4.5.8 Байгаль орчны аудит хийлгэсэн байх

2023 оны Байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөөний хүрээнд Байгаль орчны аудитыг “Ногоон гэрэлт ирээдүй” ХХК-иар хийж гүйцэтгүүлсэн болно. Тус аудитын дүгнэлтийн дагуу байгаль орчныг хамгаалах ажлын зөвлөмжүүдийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

2023 онд Байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэд зарцуулсан дүн

№	Зардлын төрөл	2023 он /төг/ төлөвлөгөө	2023 он /төг/ биелэлт
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	1,700,0	12,430,000
2	Ногоон байгууламжийн зардал	2,000,000	1,850,000
3	Тэрбум мод – үндэсний хөдөлгөөний хүрээнд хийгдэх ажлын зардал	1,312,000	1,020,000
4	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	0,0	0,0
5	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний зардал	2,100,000	2,250,000
6	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр хэрэгжүүлэх зардал	737,600	10,925,000
7	Байгаль орчны аудит	5,000,000	5,600,000
8	Удирдлага-зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөө	500,000	1,350,000
9	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	0	200,000
НИЙТ		19,988,000 ₮	35,625,000₮

2023 онд Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардалд 35,625,000 (гучин таван сая зургаан зуун хорин таван мянган) төгрөгийг зарцуулсан болно.